

КРИПТО ҮНДЭСТЭН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Крипто Үндэстэн ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, А.Амарын гудамж 2, Централ тауэр 17 давхар Криптос ресторан 11:00 цагаас эхлэв.

Хурлын дэг:

11:00-11:15 Тооллогын комисс хурлын ирц бүртгэх, ирцийг мэдээлэх;

11:15-11:25 Хурлын дарга хурлыг нээж, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах;

11:25-11:50 Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулга хийх

1. Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;

2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;

11:50-12:10 Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт

12:10-12:20 Санал хураалт

12:20-12:30 Санал хураалтын дүнг нэгтгэн, Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах

12:30-12:40 Хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж хурлыг хаах

Хуралд оролцсон:

Хурлын дарга: Ч.Ганхуяг (Ард Санхүүгийн Нэгдэл ХК)

Хурал зохион байгуулсан зохион байгуулах багийн гишүүд:

О.Мөнх-Оргил (Крипто үндэстэн ХК)

Ц.Энхтүвшин (Ард Бит ХХК)

Б.Уранцэцэг (Ард Бит ХХК)

Тооллогын комисс:

Тооллогын комиссын дарга:

Ө.Бямбагэрэл (Ард Секюритиз ҮЦК ХХК)

Тооллогын комиссын гишүүд:

Т.Батбаяр (Ард Секюритиз ҮЦК ХХК)

Б.Тэлмүүн (Крипто Үндэстэн ХК)

Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил хувьцаа эзэмшигчдэд хандан мэнд дэвшүүлж, талархал илэрхийллээ. Хурлын дэгийн дагуу тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл ирцийг танилцуулахыг урив.

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл:

1. Кripto Үндэстэн ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 2023 оны 3 сарын 15-ны өдрийн 24/02 тоот тогтоолыг танилцуулав.
2. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дугаар хэсэг болон 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр хэсгийг тус тус үндэслэн Кripto Үндэстэн ХК-ийн ээлжит хурлын ирц саналын эрх бүхий саналын эрхтэй **102,184 ширхэг энгийн** хувьцаанаас **59,723 ширхэг** буюу **58.45** хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байна. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр хэсгийг үндэслэн тус **хурал хүчин төгөлдөр болно.**

Хурлыг нээж ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг

Crypto week 7 өдрийн арга хэмжээний 3 дахь өдөр үргэлжилж байна. Ардын мэдээ сонинд бүх компаниудын мэдээлэл орсон байгаа. 2020 онд Булган Ундрага ХК-ийг аваад Кripto Үндэстэн ХК-ийг хувьцаат компани болгож Монголын хөрөнгийн бирж дээр BUN нэртэй хувьцаа зарагддаг байсан бол одоо CNF нэртэй хувьцааны арилжаа явагдаж байгаа.

Өнөөдөр Кripto Үндэстэн ХК нь үйл ажиллагаагаа явуулж байна. Бид дэлхийн зах зээлээс түрүүлж хөдөлж чадсан ч хамтдаа буюу илүү олуулаа байж чадаагүй. Монголчууд бид 2021 онд крипто салбарыг анх эхлүүлэхэд хэт олон компаниуд буруу таниулж үйл ажиллагаа луйвар болгож хувиргасан түүний дараа крипто өвөл болж бид үүнээс хойш хүнд 3 жилийг давж байна. Бидний 3 жилийн төлөвлөгөө Ардкойны уналтыг бууруулах зөөлөн газардуулахад анхаарч ажилласан. Бид 100 хувь Кripto Үндэстэн ХК-ийг удирдахад анхаарч чадаагүй нь компанийн үйл ажиллагааг үр дүнд хүргээгүй. Кripto Үндэстэн ХК-ийн Гүйцэтгэх захирлаар сарын өмнө томилогдсон О.Мөнх-Оргил маань тайлангаа танилцуулна. Crypto week 7 өдрийн арга хэмжээг энэ жил ажлын байрандаа зохион байгуулж байгаа нь хувьцаа эзэмшигч нар маань эзэд учраас үйл ажиллагааг харж эзний ёсоор хандах нь зүйтэй байх гэж найдаж байна.

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Өнөөдрийн хурлын ирц хангаж байгаа тул Кripto Үндэстэн ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаа эхлүүлэе. Хувьцаа эзэмшигчдэд хурлын дэгийг танилцуулав. Өнөөдөр дараах асуудлуудыг хэлэлцүүлэх болно. Үүнд:

Хэлэлцсэн нь №1:

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Кripto Үндэстэн ХК-ийн Үйл ажиллагааны тайлан.

Кripto Үндэстэн ХК нь хөрөнгө оруулсан компаниуд буюу хөрөнгө оруулалтын багц:

Кripto Үндэстэн ХК нь блокчэйн төсөлтэй хамааралтай бүх компаниудыг өөрийн бүтэцдээ нэгтгэх боломж үүсэж байна. Бид Ай Дакс ХХК, Ард Бит ХХК дор Дайверс сольюшнс ХХК буюу код бичдэг компани байна. Мөн Монгол Дифай ХХК нь монголын анхны аргамжсан токен MoNT-ийг гаргасан, krupto.mn аас арилжааны болон крипто биржүүдийн мэдээлэл датаг харах боломжтой. Мөн 2023 оны 12 сард нээлтээ хийсэн Кастоди ХХК нь биднийг өөрсдийн хэтэвчтэй болж байна. Өмнө нь үндсэн дансанд байсан бол одоо блокчэйн дээр гарч байна. Энэ бүх хөдөлгөөн ил тод болж байгаа бөгөөд бид ард апп дотор оруулж ирээд

бүх төрлийн крипто валютыг удирдах хэтэвчийг үүсгэсэн байна. Та бүхэнд дээрх компаниудын үйл ажиллагааг танилцуулъя.

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Ай Дакс ХХК-ийн тоон мэдээллийг танилцуулав.

Ай Дакс ХХК нь 2024 оны I улирлын байдлаар 852 (найман зуун тавин хоёр) хүн шинээр бүртгүүлсэн. Нийт 161,851 (нэг зуун жаран нэгэн мянга найман зуун тавин нэг) харилцагчаас 56,000 (тавин зургаан мянга) нь гадаад харилцагч байна. Бид тодорхой хугацаанд идэвхжүүлэлт хийж үзсэн бөгөөд энэхүү идэвхжүүлэлтээ АрдКойны шинэ хувилбартай холбоотойгоор нөгөө талаасаа idax.exchange бирж дээр гардаг “know your costumer” буюу харилцагчаа таних зардалтай холбоотойгоор түр зогсоосон байна. idax.exchange бирж дээр явагдаж буй фючерс арилжаа нь Монгол улсын виртуал хөрөнгийн биржүүд дундаа хамгийн идэвхтэй явж байгаа ба фючерс арилжаа хийж байгаа бирж Монгол улсад цөөхөн байна. 2024 оны эхний улирлын байдлаар фючерс арилжааны хувьд 26 сая доллар, Спот арилжааны хувьд 7,9 сая долларын арилжаа явагдсан байна. Хэдий крипто өвөл ирсэн ч арилжаа хийх нь арилжаагаа хийгээд сурах нь сураад явж байна. idax.exchange бирж нь нийт 93 энгийн арилжааны хослолтой, 25 гаруй блокчэйн сүлжээг дэмжиж ажилладаг.

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Ай Дакс ХХК-ийн 2024 онд хийгдэж ажлын төлөвлөгөө танилцуулав.

Гадаад дотоодруу чиглэсэн маркетинг бөгөөд бид койнмаркетинг дээр гарах гэж төлөвлөөд судалгааны ажлууд хийгдээд явж байна. Дотоод системийн хөгжүүлэлтийг сайжруулаад явж байна. Мөн hotwallet буюу coldwallet маань өмнө нь Ай Дакс ХХК-ийн лицензийн хүрээнд хийгддэг байсан бол одоо Кастоди хэтэвч дээр хийгдээд явж байна.

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Ард Бит ХХК-ийн (Ардкойн) тоон мэдээллийг танилцуулав.

Бид 2023 оны 12 сард нөөцөөс ахин 100 сая ардкойн устгалд оруулсан байна. Одоогоор ардкойны нөөц анх 5.1 тэрбум Ардкойн байснаас 4.5 тэрбум ардкойн зах зээлд эргэлтэд байна. Одоогийн байдлаар нийт 478,000 (дөрвөн зуун далан наян мянга) гаруй харилцагч ардкойн эзэмшдэг, зах зээлийн үнэлгээ 78,5 тэрбум бөгөөд өдөрт явагддаг арилжаа маань 2024 оны 3 сарын байдлаар 90.9 сая төгрөгийн арилжаа 24 цагийн дотор хийгдэж байна. Мөн бид Ардкойныг зөвхөн харилцагч нартаа урамшууллаар олгодог байснаа хүрээгээ тэлж бусад байгууллага дэлгүүрүүдийг мерчантаар элсүүлж ардкойн урамшууллын оноогоор олгож байна. Ардкойнтой хослолууд маань idax.exchange бирж дээр нийт 22 байна.

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Ард Бит ХХК-ийн (Ардкойн) 2024 онд хийгдэж ажлын төлөвлөгөө танилцуулав.

Бид бүхэн интернет банктэй болж байгаа. Үүн дээр ардкойны хөгжүүлэлт хараахан дуусаагүй байна. Энэ ажил дуусахаар манай мерчантууд өөрсдийн касс, поссын системтэй холболт хийх боломжтой болж байна. Мөн кастоди хэтэвчний 2 дугаар үеийн хөгжүүлэлт хийгдэж байна. Мост мони хэтэвч дээр мөн ардкойны урамшуулал авах ажил хийгдэж байна. Ардкойн дээр хамгийн том хийгдсэн ажил маань 2023 оны 12 сард ардкойны 3.V нээлтээ хийсэн. Шинэ мэдээ дуулгахад бид гүйлгээний шимтгэлд 100-300 төгрөг төлөн байсан маань 1 төгрөг болж байгаа. Энэ ажилд маань аудит хийгдэж байгаа бөгөөд бид нээлтээ 5 сард хийнэ гэж найдаж байна.

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Монгол Дифай ХХК-ийн тоон мэдээллийг танилцуулав.

Монгол Дифай ХХК хувьд нийт нийлүүлэлт 2.1 тэрбум, 100,000 (нэг зуун мянга) MoNT эзэмшигч, дундаж блокчэйн гүйлгээний дүн 14 сая, 2024 оны эхний улиралд нийт 7.5 тэрбум блокчэйн гүйлгээ хийгдсэн. Бид ирээдүйд бүх токен салона дээр гаргах боломжтой болж байна. Бид өөрсдийн бүх токенуудаар хооронд нь гүйлгээ хийх боломжтой болж байгаа.

Хэлэлцсэн нь №2:

Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Крипто Үндэстэн ХК нь Санхүүгийн тайланг танилцуулав.

2023 оны 12 сарын 31-ний байдлаар нийт хөрөнгө 5.7 тэрбум болсон байна. Нийт өр төлбөрийн дүн 770 гаруй сая төгрөг, эздийн өмчийн дүн 5 тэрбум байна. Та бүхэн мэдэж байгаа байх дэлхийн зах зээл дээр арилжаалагдаж байгаа койн маань өсөлттэй байгаа. Бидний хөрөнгө оруулалтын багцад эдгээр койнууд байгаа. Тэгэхээр бидний өнөөдрийн үнэлгээ үүнээс өндөр байгаа.

2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн хувьд бид 2023 оны нийт орлого 47,7 сая төгрөг нийт зардал маань 136 сая, татварын өмнөх ашиг алдагдал маань 88 сая байна. Үүний задаргааг харуулья.

Мэдээлэл болгоод хэлэхэд бид TON токеныг 4 доллароор тооцож авах хэлцэл хийгээд шилжүүлэлт хийгдээд явж байна.

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц танилцуулав.

Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил нь Хүлэгт Хүннү Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал И.Гүррагчаа захирлыг аудитын дүгнэлтийг танилцуулна уу хэмээн урив.

Танилцуулсан: Хүлэгт Хүннү Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал И.Гүррагчаа

Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Хүлэгт Хүннү Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал И.Гүррагчаа байна. Крипто Үндэстэн ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа дүгнэлтийг танилцуулахаар хүрэлцэн ирсэн байна. Крипто Үндэстэн ХК-д өгсөн зөвлөмж залруулгын нэгтгэлүүдийг хүлээж авсан тул бид аудитлагдсан тайландаа стандарт буюу зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Крипто Үндэстэн ХК-ийн “Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг захирлыг урьж байна.

КРИПТО ҮНДЭСТЭН ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ДҮГНЭЛТ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагч та бүхэнд Крипто Үндэстэн ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг Төлөөлөн Удирдах зөвлөлийн (цаашид “ТУЗ” гэх) хурлаар хэлэлцэн та бүхэнд танилцуулж байна. Крипто Үндэстэн ХК-ийн ТУЗ нь тайлант онд компанийн удирдах үйл ажиллагаандаа Компанийн

тухай хууль, холбогдох хууль тогтоомжийг мөрдөн дараах ажлыг амжилттай хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөн, хуулийн хүрээнд ажиллаж эхлэв.
- Зах зээлийн өсөлттэй уялдуулан шаардлагатай криптовалютуудыг арилжаалж, хөрөнгийг хамгаалахад анхаарч ажиллаж байна.
- Хууль эрх зүйн хүрээнд шаардлагатай бүртгэлийг холбогдох байгууллагуудад хийлгэв.

Компани нь 2023 оны жилийн эцэст 5.8 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, 770 сая төгрөгийн өр төлбөр, 5 тэрбум төгрөгийн эздийн өмчтэй байна. Нийт хөрөнгийн хэмжээ өмнөх жилийнхтэй харьцуулахад 16.2%-ийн өсөлт үзүүлсэн байна.

ТУЗ нь улирал бүр гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд хяналт тавьж, компанийн үйл ажиллагаа явуулж буй салбарт судалгаа шинжилгээ хийж, чиглэл өгч ажилласан. Иймд 2023 онд Крипто Үндэстэн ХК-ийн хувьд ТУЗ, удирдлага нарыг амжилттай ажилласан гэж дүгнэж байна.

ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг: Хэлэлцэх асуудлуудтай холбоотой асуулт бий юу?

Асуулт. С.Оргодол: Өдрийн мэнд, хэдхэн асуулт байна. Аудитор 4 дүгээр сарын 28 гэсэн та буруу хэлсэн үү.

Хариулт. Хүлэгт Хүннү Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал И.Гүррагчаа: 3 сарын 28-ны өдөр тайлан хүргүүлсэн байгаа.

Асуулт. С.Оргодол: Гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн даргаас асууя. Ойрын 3 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө юу байна вэ. Дэлхий даяар ETF гэж том хандлага байна. Крипто Үндэстэн ХК нь өөрөө цаашдаа ETF болж явах уу. Хувьцааны тоог олшруулж хувааж, жижиглэх үү гэсэн асуултууд байна.

Хариулт. Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил: энэ жил хийгдэхээр төлөвлөж байгаа ажил маань шинэ хөрөнгө оруулагч татах, үүний тулд хувьцаагаар баталгаажсан токен гаргахаар судалгаа хийж ажиллаж байна. Мөн биткойн, этериум өсөлттэй байгаа учраас бид өөрсдийн эзэмшиж байгаа хөрөнгөө барьцаалж зээл авах төлөвтэй байна. Мөн та бүхэн мэдэж байгаа байх AIG нэртэй толгой компани гарч ирж байгаа. Үүн рүү бид шилжих ажил хийгдэж байна. Мөн Крипто Үндэстэн ХК нь бонд гаргах төлөвлөгөө байна. Зарим ажлууд хийгдээд эхэлчихсэн байна.

Хариулт. ТУЗ-н дарга Ч.Ганхуяг: Шинээр мөнгө оруулж ирдэг бизнес бол байгаагүй. Өмнөх хэтэвчинд хийсэн зүйлсээ хараад сууж байсан. Зардлаа бага түвшинд байлгаад явсан. Бид энэ оноос өөр өөр ажиллаж эхлээ гээд ажиллаж эхэлсэн байна. 3-5 тэрбум төгрөгийн хөрвөх боломжтой бонд гаргаад хөрөнгө оруулалтын багцаа нэмж ажиллая. Ард бит ХХК нь 100 хувь Крипто Үндэстэн ХК-ийн дор үйл ажиллагаа явуулах болсон. Ардкойнтой холбоотой ажлууд хийгдэж байна. Мөн үнэт цаасны токен кастодианы үйлчилгээг нэвтрүүлэх зорилго тавьсан байна. Мөн хувьцаа хуваах ажил хийхээр шийдсэн байна. Хувьцаагаар баталгаажсан токен гаргаж өөрсдийнхөө биржид гаргах ажил хийнэ. Банкны гүйлгээний шимтгэлийг бууруулахаар зорилго тавин ажиллаж байна.

Асуулт. С.Оргодол: Тодруулга байна. Хувьцаа хуваана гэж байна. Энэ талаар өмнөх жилүүдэд ярилцаад хуваахгүй болсон. Хэрвээ хуваах бол ХЭХ-ын хурлаар хэлэлцэж шийдэх нь зөв байна. Бонд гаргана гэж ярьж байгааг мөн ХЭХ-ын хурлаар хэлэлцэх асуудал байна. Мөн нэг асуултад хариулаагүй. ETF гаргах уу энэ талаар хариулт өгөөч.

Хариулт. ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг: Хувьцаа хуваана гэж ярьж байгаа. Өмнө нь шилжүүлнэ гэж яриад зохицуулалтын асуудал үүссэн. Учир нь зохицуулалтын журам нь байгаагүй одоо тэр журмаа батлах байх. Бид хувьцааг хуваах асуудал ярьж байгаа, энэ нь хувьцааг токенжуулаад

хэсэгчлэн авах боломжийг олгож ард иргэдэд хүртээмжтэй байдал бий болгож байгаа юм. 2 дох асуудал бол бид ном журмын дагуу асуудлаа шийднэ. 3 дах асуудал ETF-ийг гаргах ажлыг зохион байгуулах талаар ТУЗ-тэй хэлэлцэж байгаад хийх байх.

Асуулт. Ч.Нямдорж: Хүлэгт Хүннү Аудит ХХК-ийн аудитын гаргасан тайлан өөрөө 4 тайлангийн залруулагтай байх ёстой. Тайлангийн тодруулгууд яагаад байхгүй байгааг тайлбарлана уу. Энэ нь хувьцаа эзэмшигч нарыг бодит мэдээллээр хангаж чадахгүй байна гэж үзэж байна. Би энэ тайланг батлахаас татгалзаж байна.

Хариулт. Хүлэгт Хүннү Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал И.Гүррагчаа: Бид бол 30-д хуудастай санхүүгийн тайлан хүргүүлсэн байгаа. Энэ дээр яаж тайлагнах нь хурал зохион байгуулж байгаа баг шийдэх асуудал байх. Дэлгэрэнгүйгээр нь Хөрөнгийн биржээс үзэж болох байх аа.

Хариулт. ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг: Тайланг бид ТУЗ-өөр хэлэлцээд гаргаж ирсэн асуудал байна.

Асуулт, хариулт дуусав.

Санал хураалт явуулав.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл: Кripto Үндэстэн ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын №02 тоот тогтоолын санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

Санал хураалт:

1. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалтын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж, санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн ТОГТООХ НЬ:

Хурлаар хэлэлцсэн Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудалд, хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 59,723 ширхэг буюу 58.45 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

1.1. Зөвшөөрсөн: 59,623 ширхэг буюу 99.83%

1.2. Татгалзсан: 12 ширхэг буюу 0.02%

1.3. Түдгэлзсэн: байхгүй байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг хурлыг хаан үг хэлэв.

Хурал 13 цаг 00 минутад дуусав.

ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

Ч.ГАНХУЯГ

Б.УРАНЦЭЦЭГ

